



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.04.11-2022.04.15



ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.04.18-ны байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
DOW	34302.00	-0.42%	-0.02%	-0.73%	0.66%
S&P 500	4364.43	-0.64%	-1.10%	-2.27%	4.83%
NASDAQ	4364.43	-0.99%	-1.69%	-4.62%	-1.10%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7616.00	0.47%	0.86%	6.14%	9.06%
DE40	14,283.67	0.62%	0.61%	1.77%	-7.15%
FR40	6,548.22	0.72%	1.98%	3.69%	5.70%
IT40	21,050.96	0.57%	2.30%	5.80%	1.36%
ES35	8,467.40	0.94%	2.74%	5.62%	1.49%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	26,598.00	-1.79%	-1.29%	3.40%	-10.26%
SHANGHAI	3,211.00	0.00%	1.39%	-1.30%	-7.66%
CSI 300	4,189.00	0.00%	2.16%	-1.64%	-17.66%
CH50	13,982.81	-0.12%	0.37%	4.96%	-16.91%
SENSEX	59,447.00	-0.41%	-2.13%	3.28%	19.54%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	107.95	0.88%	14.49%	-1.84%	70.19%
Газрын тос (Brent)	112.97	1.21%	14.77%	0.99%	68.58%
Байгалийн хий	7.5350	2.92%	13.46%	53.82%	174.17%
Шатахуун	3.4143	1.20%	13.70%	2.29%	67.01%
Нүүрс	314.00	0.64%	10.18%	-13.14%	235.83%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1,984.17	0.48%	1.63%	2.54%	12.20%
Мөнгө	25.90	0.83%	3.30%	2.80%	0.35%
Зэс	4.77	1.13%	3.20%	1.60%	12.39%
Бонд	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	2.8486	0.0211	0.07%	0.55%	1.25%
Англи	1.8880	0.0830	0.16%	0.31%	1.15%
Швейцар	0.2400	0.0010	0.15%	0.47%	1.35%
Испани	1.7930	0.0200	0.08%	0.45%	1.40%
Португаль	2.9140	0.0600	0.08%	0.26%	2.01%

Эх сурвалж: Trading economics

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Инфляцын түвшин дээд цэгтээ хүрсэн байж магадгүй

3 сарын инфляцын мэдээ саяхан гарсан бөгөөд тус мэдээгээр хэрэглээний үнийн индекс (CPI) болон үйлдвэрлэгчдийн үнийн индекс (PPI) тодорхой болсон юм.

- АНУ-ын хэрэглээний үнийн индекс 3 сард 8.5% гарсан нь сүүлийн 40 жилд үзэгдээгүй дээд түвшин юм. Харин хоол хүнс, эрчим хүчний үнийг оролцуулаагүй гол хэрэглээний үнийн индекс 6.5% гарсан нь шинжээчдийн таамагласан 6.6%-иас бага байлаа.
- Үйлдвэрлэгчдийн үнийн индекс 3 сард 11.2% хүрсэн нь түүхэнд хамгийн дээд түвшин юм.



Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Инфляцын түвшин хэдий хүчтэй өсөж байгаа ч шинжээчдийн үзэж байгаагаар дээд цэгтээ хүрсэн байж магадгүй ба дараагийн хэдэн 7 хоногоос буурах төлөвтэй. Өсөлтөд хамгийн их нөлөөлж байсан эрчим хүч, түүхий эдийн ханш сүүлийн хэдэн 7 хоног харьцангуй тогтвортой байлаа. Жишээлбэл, газрын тосны ханш 3 сард дунджаар 108 доллар байсан бол 4 сар гараад 99 доллар болоод байна. Энэ нь хэдэн сарын дараагаас инфляцын түвшин цаашид буурах төлөвтэй байж магадгүй гэсэн найдлага төрүүлж байна.

Түүхий эд болон газрын тосны ханшийн давхцал



Инфляцын түвшин хэдийн хугацаанд хэвийн түншиндээ буцаж очих вэ?



Улсын дундаж инфляц ойрын хэдэн сард буурч магадгүй ч гол инфляц (хоол хүнс, эрчим хүч ороогүй) илүү удаж байж буурдаг зүй тогтолтой. Жишээлбэл, орон сууц, байрны үнэ хэрэглээний үнийн индексийн сагсны 1/3-ийг бүрдүүлдэг ба сүүлийн үед эрэлт өссөн үед хангалттай нийлүүлэлт байхгүйн улмаас үнэ ихээхэн өссөн.

Бодлогын хүү өсөж байгаатай холбоотой орон сууцны зээлийн хүү өсөж байгаа нь худалдан авалтын эрэлт буурахад нөлөөлөх хэдий ч инфляцыг бууруулах хүртэл нөлөөлөхөд багагүй урт хугацаа орж магадгүй.

Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Шинжээчдийн үзэж байгаагаар инфляцын түвшин 2022 оны сүүлийн хагас жилээс эхлэн мэдэгдэхүйц буурах болов уу гэж харж байна. Инфляцын түвшинд гол нөлөөлж байгаа хүчин зүйлс нь түүхий эдийн үнэ болон нийлүүлэлтийн асуудалд оршиж байна. Түүхээс харахад, өмнө нь инфляцын түвшин дээд хэмжээнээсээ доод хэмжээнд хүрэхэд дунджаар 24-36 сар болдог тул хэвийн түвшин буюу 2%-д хүрэхэд тодорхой хугацаа орох нь ойлгомжтой болж байна.

Одоогоор шинжээчдийн анхаарал татаж байгаа сэдвүүд

Энэ жилийн эхний улирлын компаниудын санхүүгийн тайлан: S&P 500 компаниудын улирлын санхүүгийн тайлангууд өнгөрсөн 7 хоногоос гарч эхэлсэн билээ. J.P. Morgan, Morgan Stanley болон Goldman Sachs гурван том банкны тайлангаас бид эдийн засаг болон худалдан авалтын чиг хандлагын талаар бага зэрэг ойлголттой болж авсан. Хэдий компаниудын тайлан, зээлийн эрэлт өссөнтэй холбоотой таамгаас илүү гарсан ч АНУ болон олон улсын эдийн засгийн нөхцөл байдалд тодорхой эрсдэлүүд үүсэж байгаа талаар анхааруулсан. Гэсэн хэдий ч S&P 500 компаниудын ашиг энэ жил дунджаар 9.5%-иар өсөх төлөвтэй байна.

Төв банкнууд бодлогын хүүгээ өсгөж эхэллээ: Өнгөрсөн 7 хоногт нэлээн хэдэн хөгжингүй орнуудын төв банкнууд АНУ-ын ХНС-тай адил бодлогын хүүгээ өсгөж эхэлжээ. Канадын төв банк гэхэд бодлогын хүүгээ өнгөрсөн 7 хоногт 0.5 хувиар өсгөж нэмж хөрөнгө худалдан авч балансаа зузааруулахыг зогсоохоо мэдэгджээ. Шинэ Зеланд болон БНСУ-ын төв банкнууд бодлогын хүүгээ 0.25%-иар тус тус өсгөсөн бол Европын холбооны төв банк бодлогын хүүг одоохондоо 0.0% дээр байлгахаар шийдвэрлэв.

Эдгээр улс орнуудын төв банкнуудын үйлдэл нь АНУ-ын ХНС-ийн 5 болон 6 саруудад бодлогын хүүг 0.5%-иар өсгөж, балансаа сар бүр 95 тэрбум доллароор бууруулах магадлалыг илүү баттай болгож өгч байна. Хэрвээ ХНС-ийн энэхүү хатуу бодлого инфляцын түвшнийг тодорхой хэмжээгээр бууруулах юм бол цаашдын баримтлах бодлогоо зөөлрүүлж магадгүй юм. Мөнгөний бодлого зөөлөн болох нь хөрөнгийн зах зээлд эерэгээр нөлөөлдөг билээ.



Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Инфляцын түвшин өндөр, эдийн засгийн өсөлт саарсан ийм үед хэрхэн хөрөнгө оруулалт хийх нь оновчтой вэ?

Шинжээчдийн үзэж байгаагаар хэдий эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй байгаа ч хөрөнгийн зах зээл дараагийн 12 сарын хугацаанд өснө гэсэн байр суурьтай байна. 2022 онд хямрал болно гэж харахгүй байгаа ч хөрөнгийн зах зээлд ихээхэн хэлбэлзэл байх тул багцаа төрөлжүүлэхийг сануулах нь зөв болов уу.

Хөрөнгийн зах зээл сүүлийн 3 жил хүчтэй өссөний эцэст энэ жилээс унаж эхэллээ. АНУ-ын S&P 500 индекс жилд дунджаар 15%-иар өсдөг бол сүүлийн 3 жил 20 гаруй хувиар өссөн юм. Харин энэ жилийн эхний улирлын байдлаар 6.5%-иар унасан байгаа нь цаашид өсөх магадлал байгаа тул одоо тодорхой хэмжээгээр авч байх нь зөв гэж үзэж болохоор байна.

Хөрөнгийн зах зээл дотроос defensive болон value хувьцаануудыг авах нь одоогийн нөхцөл байдалд илүү нийцэх ба эрүүл мэндийн, хэрэглээний болон үйлдвэрийн салбарууд инфляц ихтэй үед илүү сайн өсдөг.

S&P 500 индексийн жилийн дундаж өгөөж



Эх сурвалж: www.edwardjones.com